



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 4/24

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар  
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 166,533,254.96 (нэг зуун жаран зургаан сая таван зуун гучин гурван мянга хоёр зуун тавин дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг (Ц.Мөнхжаргал)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 1,495,167.20 (нэг сая дөрвөн зуун ерэн таван мянга нэг зуун жаран долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 5 нэр төрлийн 2,558,389.76 (хоёр сая таван зуун тавин найман мянга гурван зуун наян есөн төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 30,000 (гучин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 9,000 (есөн мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэх, 2 нэр төрлийн 162,479,698 (нэг зуун жаран хоёр сая дөрвөн зуун далан есөн мянга зургаан зуун ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг (Ц.Мөнхжаргал)-т, татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА

М.БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2022 оны 02 дугаар сарын 04-ны  
өдрийн 17 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

/гөргөөр/

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 55 дугаар цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Тоо хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдэрч гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
1	Угаалгын машин	6	ш	2	214,000.00	428,000.00	428,000.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	устгах
2	Махны машин	6	ш	1	259,705.76	259,705.76	259,705.76	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	худалдах
3	Дээжний хөргөгч	6	ш	1	129,852.88	129,852.88	129,852.88	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	устгах
4	Ногоо арилгагч	6	ш	1	151,882.32	151,882.32	151,882.32	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	устгах
5	Зөөврийн компьютер"Дэлл"	10	ш	1	1,034,000.00	1,034,000.00	1,034,000.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	худалдах
6	Өнгөт принтер	10	ш	1	682,000.00	682,000.00	682,000.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	устгах
7	Компьютер "Асер"	10	ш	1	946,000.00	946,000.00	946,000.00	-			худалдах
8	Цахилгааны дэд өртөө	6	ш	1	161,115,698.00	161,115,698.00	161,115,698.00	-	Ашиглалтгүй	Актлах	татах
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>9</b>		<b>164,747,138.96</b>					
9	Үндэсний хөгжим /ятга, ёочин, шанз/	25	ком	1	246,324.00	246,324.00	246,324.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	худалдах
10	Индүүний тавиур	6	ш	2	51,716.00	103,432.00	103,432.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	устгах
11	Хүүхдийн пивор сандал	6	ш	100	13,640.00	1,364,000.00	1,364,000.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	татах
12	Шанз хөгжим	29	ш	1	72,360.00	72,360.00	72,360.00	-	Эвдэрч гэмтсэн	Актлах	худалдах
<b>Төвилга эд хогшлын дүн</b>				<b>104</b>		<b>1,786,116.00</b>					
<b>Нийт хөрөнгийн дүн</b>				<b>113</b>		<b>166,533,254.96</b>					
Үүнээс: худалдан борлуулах хөрөнгийн дүн						2,558,389.76					
Устгах хөрөнгийн дүн						1,495,167.20					
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн						162,479,698.00					
Худалдсанаас олох орлого						30,000.00					
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/						9,000.00					